



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭЭДЭЭ

155 /155/

2021.10.13

## Цахим шууданд

### ЗХЖШ-ЫН ДАРГА АНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Материал, техникийн газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр нар 2021 оны 10 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд тус ангийн үйл ажиллагаатай танилцан бие бүрэлдэхүүнтэй уулзаж Зэвсэгт хүчинд хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудын талаар товч мэдээлэл өглөө. Мөн тус ангийн нийт офицер, ахлагч нарыг амьдрал ахуйгаа ажил албаа зөв төлөвлөн цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэн сурч хөгжихийг эрхэм болгож ажиллахыг захиж зөвлөлөө.

Ахмад Н.МӨНХБААТАР



## Түүхэнд энэ өдөр

1926 он:

Бүх цэргийн Ерөнхий сургуулийн газар нам ба улс төрийн сургуулийг дахин байгуулжээ.

1936 он:

ЦЯЯ-ны Бүх цэргийн жанжин маршал Г.Дэмидийн 142 тоот тушаалаар жанжин штабын дарга нарын хэлтсийн даргын ажлыг Жанжин штабын орлогч, дивиз командлан захирагч М.Гомбод хавсаргав.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
8	-4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
30	22

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,850.00	2,852.00
EUR	3,300,0	3,312,0
CNY	441,70	442,80
RUB	39,30	39,80
JPY	25,20	25,50
KRW	2,38	2,40

## ЗУРХАЙ

2021.10.13 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 8/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ МОРЬ

Үс засуулбал: **НАС УРТАСНА.**

Наран ургах, шингэх: **07.08-18.08**

Барилдлага: **Идэр**

Шүтэн барилдлага: **Нэр өнгө**

Суудал: **Мод**

Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртадна.

### “ТУСЛАХ АЖ АХУЙН АШИГ ШИМ-2021” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



#### Зэвсэгт хүчний 189 дүгээр анги

Мал амьтад өсгөн үржүүлж ашиг шимийг бүрэн ашиглах, хоёрдогч түүхийг эдийг ашиглах, аль болох бага зардалтай харьцангуй хямд үнэтэй бүтээгдэхүүнээр анги хамт олны хэрэгцээг хангахад хувь нэмэр оруулах, хоёрдогч түүхийг эдээр хийх хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, тогооч нарын ур чадварыг ахиулах зорилготойгоор “Туслах аж ахуйн ашиг шим 2021” өдөрлөгийг зохион явууллаа.

Жил бүрийн намар явуулдаг тус өдөрлөгт оролцсон бүрэлдэхүүнд материал хангалтын албанаас 13 нэр төрлийн цагааны идээ, 6 нэр төрлийн хүнсний ногоо, 11 нэр төрлийн даршилсан 82 шил ногоо, хоёр нэрийн мах, дайвар бүтээгдэхүүнээр хийсэн 20 нэр төрлийн сонголттой хоол зэрэг бүтээгдэхүүнээр үйлчиллээ.

Туслах аж ахуйн малчин Х.Өгөөдэй нь хоёр сарын хугацаатай малын сүү сүүн бүтээгдэхүүнээр 13 нэр төрлийн 40 кг ааруул, эззгий, бяслаг, өрөм, 40 кг тараг, долоон кг аарц, 40 л сүү, 20 л нэрмэл бэлтгэж бие бүрэлдэхүүнд хямдралтай үнээр худалдаалсан юм. Түүнчлэн энэ үеэр материал хангалтын албаны үйлчлэгч Б.Тэгшжаргал нь нойтон өрмөөр бие бүрэлдэхүүнд хайлмаг хийж амталгаа явуулсан нь олны талархлын хүлээв.

Зэвсэгт хүчний 189 дүгээр анги Хонхорын дамжуулах төв болон удирдлагын хамгаалагдсан байрын ашиглалтгүй талбайг ашиглаж 173 мкв талбайд хүнсний ногоо, нарийн ногоо, 142 мкв хэмжээтэй гурван хүлэмжид өргөст хэмх, улаан лооль, нарийн ногоо, 0,8 га газар төмс тариалж нийт 800 кг төмс, хүнсний ногоо, 128,6 кг улаан лооль, өргөст хэмх хураан авсан.

Түүнчлэн бэлтгэгч тогооч Б.Наранбямба нь 1 сарын хугацаатай 11 нэр төрлийн 82 шил нарийн ногоо даршилж, ангийн хаяг шошгыг хийж, бие бүрэлдэхүүнд амтлуулж хямдралтай үнээр худалдаалсан юм.

Хонхорын дамжуулах төв болон удирдлагын хамгаалагдсан байрын ашиглалтгүй талбайг ашиглаж 173 мкв талбайд тариалсан төмс хүнсний ногоог бие бүрэлдэхүүнд хямдралтай үнээр худалдаалж, үлдсэн ногоог ангийн цайны газарт оруулахаар хатааж ялгалт хийн хадгалалтад шилжүүллээ. Мөн энэ үеэр дөрвөн малын дотор гэдсээр 17 нэр төрлийн 50 порц 1, 2 дугаар хоол, 13 кг хонины махаар: амталж шарсан гуя, амталж шарсан өвч, гүзээний хорхог зэрэг амтат хоол хийж бие бүрэлдэхүүнд худалдаалсан юм.

Хошууч Т.ЭНХТУУЛ

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН  
321,190 +1348

ЭДГЭРСЭН  
398,930 +6477

НАС БАРСАН  
1377 +14

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
5567 +97

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
194

ЭДГЭРСЭН  
5264

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 239,009,337

Эдгэрсэн

Нийт: 216,246,730

Нас барсан

Нийт: 4,872,405

Цахим шууданд

# “ГАЛ ТОГООНД ГАЦСАН ЭМЭГТЭЙ”



Төрийн тусгай албанд хүчин зүтгэдэг эмэгтэйчүүдийн амьдралыг бид сайн мэднэ. Ажил, гэр бүл, үр хүүхэд гэсээр өөрийгөө мартах нь энүүхэнд байдаг шүү дээ. Нэгэн хэвийн тойрогт хөврөх өдөр тутмын амьдралыг “Гал тогоонд гацсан эмэгтэй” хэмээн цолломоор санагдлаа. Энэ тойрогтоо удаан байж, гацахгүйгээр, өөрийн болоод гэр бүл, үр хүүхдээ хөгжүүлж, цаашлаад хамт олондоо эергээр нөлөөлж чаддаг, хүчирхэг эмэгтэй байгаасай гэсэн үүднээс ангийн эмэгтэй бүрэлдэхүүний дунд “Гал тогоонд гацсан эмэгтэй” сэдэвт өдөрлөгийг 2021 оны 10 дугаар сарын 8-ны өдөр ангийн байрлалд зохион байгууллаа.

БХЯ, ХЗЦК, ЗХЖШ, АЦК тэдгээрийн харьяа анги, салбар, байгууллагуудад бүх төрлийн холбоо, мэдээллийн цогц үйлчилгээ үзүүлэх үндсэн үүрэгтэй Зэвсэгт хүчний 189 дүгээр ангид эмэгтэй бүрэлдэхүүн харьцангуй олон байдаг нь энэ өдөрлөгийг зохион байгуулахад чухал нөлөө үзүүлсэн. Олон сайхан ээж, эгч, охид бүсгүйчүүдээс бүрдсэн хамт олныхоо сэтгэл зүйн эрүүл мэнд, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, ажил амьдралын чиг хандлагыг ямагт эерэг байлгах, хамт олны уур

амьсгалыг дээшлүүлэх зорилтыг тавьж ажиллалаа. Өдөрлөгөө “Баянзүрх дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтэс, “Баянзүрх дүүргийн хөгжлийн төв”, “Урамтай ирээдүй сэтгэл зүйн төв”, “Баянзүрх дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс”, “Нандин урлал” гар урлалын төвтэй хамтран зохион байгууллаа.

Цаг наргүй их ажлаас түр амсхийж, өөртөө нэг өдрийг зарцуулан, ирэх өдрүүдэд эрч хүчээр дүүрэн алхах гэгээн хүсэл, өөдрөг тэмүүлэл, үзэсгэлэнт инээмсэглэлтэйгээр бидний өдөрлөг өндөрлөлөө.

Дэслэгч С.СУВДАНЧИМЭГ

# ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД АРВАЙХЭЭР СУМААР АЯЛЛАА



Зэвсэгт хүчний 256 дугаар анги 2020 оны хоёрдугаар ээлжээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдыг “Монгол түмний морины их шүтээн”

цогцолбор, “БНМАУ-ын баатар Л.Аюушийн хөшөө”, “Буга Согоот” өндөрлөг, мөн аймаг орон нутагтай танилцуулах аяллыг зохион байгууллаа.

Энэ үеэр албаа үлгэр жишээ хааж байгаа дайчдын төлөөлөл дэд түрүүч Н.Буянжаргал, байлдагч Б.Лувсан-Очир нар “Соёмбо” сонинд ярилцлага өглөө.

Гадаад мэдээ

# ОРОСЫН АРМИ ХАМЕЛЕОН БҮРХҮҮЛ ЗЭВСЭГЛЭЛДЭЭ АВНА

Оросын армийн хуягт, танкнууд ойрын хугацаанд хүрээлэн буй газар орны онцлогт тохируулан өнгөө өөрчилдөг тусгай шинэ бүрхүүлээр хучигддаг болох тухай “РИА Новости” мэдээлсэн байна.

Тус агентлагийн эх сурвалжийн мэдээлснээр өнгөлөн далдлах хамелеон бүрхүүлийг цахилгаан хром материалын үндсэн дээр бүтээж байгаа аж. Одоогоор байлдааны техникийн дуураймал модель дээр бүрхүүлийг буулган турших ажил хийгдэж байна.

Туршилт дууссаны дараа шинэ бүрхүүлийг танк, явган цэргийн байлдааны машин, хуягт тээвэрлэгч зэрэг хуягласан машины өнгөлөн далдлалтад

ашиглах аж.

Эх сурвалж шинэ бүрхүүлийн чадварын талаар ярихдаа “Орчны өнгө байдал өөрчлөгдөхөд үзүүлэх хариу өөрчлөлт секундйн хэд хуваасантай тэнцэх богино байна. Жишээлбэл, танк тал газар зогсоод түүнд тохирсон нэг төрлийн өнгөтэй байж байгаад өөр зураглал бүхий газар очлоо гэж бодоход бүрхүүл нь шинэ байрлалд очих хүртэл өнгөлөн далдлалтын өнгө ба харагдах бүтцээ богино хугацаанд өөрчлөх болно” гэжээ.

Ийм байдлаар хамелеон бүрхүүл нь дайсны телевиз ба оптик төхөөрөмж болон газар байрласан техникийн

онилох ба байршил тогтоох системийн оновчтой ажиллагаанд саад учруулна.

Бүрхүүл нь гадаргыг нь цахилгаан хром бүрхүүлээр бүрхсэн олон жижиг ялтаснаас тогтоох бөгөөд эдгээр ялтаснуудын тусламжтайгаар хүрээлэн буй газар орны өнгийг төдийгүй бүтцийг нь дуурайлгасан янз бүрийн дүрслэл бий болгож чаддаг юм байна. Гадаад орчны байдлын талаарх мэдээллийг видео камерын тусламжтай авах бөгөөд авсан дүрслэлээ тооцоолох копмлексоор шинжлээд ялтаснуудын өнгө ба бүтцийг өөрчлөх замаар шаардлагатай дүрслэлийг бий болгодог юм аж.



Фото агшин

## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНД МОРДОЦГОО ЗАЛУУСАА

Гудмад хөлчүүрхэх залуус гутлаа тосолж сурна, цэрэгт морд Гуравхан үгэнд гоморхож нударга зөрүүлээд яах вэ, цэрэгт морд Эрийн шийр зааж тэсвэр тэвчээрийг эзэмш, албанд морд Энгэр задгайлж омгорхоод худлаа загнах хэрэггүй, албанд морд Сүлдэн тамгатай малгайг тэргүүндээ залаад үз Сүр жавхлантай дүрэмт хувцсыг биендээ өмсөөд үз

Суран тэлээний чангыг атгаж зангидаад хүчээ үз Сурах ёстой эрдмийг тархиндаа суулгаад амьдрал үз Цэргийн хуаранд бужигнаж үеийн нөхөдтэй ижилсэж Цэгцхэн жагсаалын дунд цогтой алхалж дуу гарга Цэрэг шинелийн хормойд унаж тусан бүдэрч бос Цэрэг эрийн ёсоор тангараг өргөн нулимс цийлгэнүүл

Эдлэх үүргээ биелүүлж эр тэнгэрээ өөдөө бадраа Эцгийн сэтгэлийг амрааж эр хүний халааг гардаж ав Эр цэргийн албыг хааж энэ биеийнхээ хагсааг гарга Эх орноо манаж эзэнтэй гэдгээ байнга сануул... Албагүй хүнд аархах шалтгаан байхгүй Ардын цэргийн албандаа мордоцгоо залуусаа...

